

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО
БАТЛАХ ТУХАЙ**

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

Гарын үсэг

ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ (ОРШИЛ)

Монголын Төр,

Монголын ард түмэн Үндсэн хуульдаа “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм дээд зорилгыг тунхагласныг үндэслэн;

Төрийн оршин тогтнох үндэс суурь иргэнээс үүсвэртэй бөгөөд төрийн эрх мэдлийн эх сурвалж гагцхүү иргэдийн хүсэл зориг болохыг ухамсарлах үүднээс төр, иргэний нийгмийн хоорондын харилцаа нь төрөөс захирах бус, харин харилцан хүндэтгэх, зөвлөлдөх, хамтран ажиллах зарчимд суурилдаг ардчилсан ёсыг эрхэмлэн;

Төр нь Үндсэн хуулиар тунхагласан иргэний эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийг удирдах хэрэгт оролцох эрх бодитой хэрэгжих эрх зүйн, эдийн засгийн, нийгмийн хийгээд бусад баталгааг бүрдүүлэх үүрэг хүлээснийг үндэслэн;

Монгол Улсын хөгжлийг нийгмийн өргөн суурьтай, эдийн засгийн даацтай болгох, ардчилсан ёсыг бататган бэхжүүлэх, алагчлалгүй нийгмийг төлөвшүүлэх шаардлагыг харгалзан;

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төрийн үйл ажиллагааны бусад тулгуур баримт бичигт хөгжлийн үйл явцад оролцох, хувь нэмрээ оруулах, хөгжлийн үр шимээс тэгш, шударга хүртэх, төрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтад оролцох иргэний эрхийг хэрэгжүүлэх иргэний нийгмийг төлөвшүүлэх, төр-иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хангасан ардчилсан удирдлагын тогтолцоо, бүтээлч арга, хэлбэрийг хөгжүүлэх зорилтуудыг тодорхойлон тусгасныг баримтлан;

Чадварлаг, хараат бус иргэний нийгэм нь ардчиллын үнэт илэрхийлэл болоод баталгаа мөн бөгөөд төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь сайн засаглал, нийгмийн шударга ёс, хөгжлийг бүтээх чухал хүчин зүйл болохыг хүлээн зөвшөөрч;

Иргэдийн идэвх санаачилга, авьяас билэг, хүч чадлыг шавхагдашгүй нөөц хэмээн үнэлэн дээдэлж, Монголын иргэний нийгэм нь хүний эрх, үндсэн эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хамгаалан, хүний хүсэл зоригийг хамтын, нийтийн ашиг сонирхолд чиглүүлэн манлайлдгаараа нийгмийн эв нэгдлийг бататгах үүргээ бие даасан хараат бус байдал, олон янз чанар болон эв санааны үнэт зүйлсээ эрхэмлэн итгэл үнэмшилтэй, идэвх зүтгэлтэй гүйцэтгэж ирснийг сайшаан тэмдэглэж;

Төрийн болон иргэний нийгмийн байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах адил чанар болон зорилготой учраас төр, иргэний нийгмийн бүтээлч хамтын ажиллагаа нь улсын хөгжлийг хангах суурь стратеги мөн гэж үзэж,

энэхүү бодлогоор иргэний нийгмийн тухай үндсэн ойлголт болон ардчилсан төр, иргэний нийгмийн харилцаа, түншлэлд эрхэмлэх үнэт зүйлс, сахих зарчмуудыг тодорхойлсон, иргэний нийгмийн хөгжлийг дэмжсэн, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг төгөлдөржүүлэхэд чиглэсэн төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын хүрээг Үндсэн хуульд заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгоор баримжаалан тогтоож байна.

ХОЁР.ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

2.1.Иргэний нийгэм гэж иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо албан болон албан бус бүлэгт сайн дураараа нэгдэн эсхүл дан ганцаараа улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор орон нутаг, салбар, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.

Үүнийг иргэд өөрийн санаачилгаар эвлэлдэн нэгдэж эсхүл дангаар нийтлэг ашиг сонирхол, зорилго, үнэт зүйлсийн төлөө төр, зах зээл, гэр бүлээс гадуур үйл ажиллагаа явуулдаг талбар хэмээн дэлхий нийтэд томьёолдог. Олон төрөл хэлбэрийн байгууллага, бүлгээс бүрдсэн иргэний нийгмийг “ашгийн төлөө бус”, “сайн дурын”, “нийгмийн”, “буяны”, “гуравдах хэвшил” гэж нэрлэдэг.

2.2.Сүм хийд, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, улаан загалмайн байгууллага зэрэг эрх зүйн тусгай зохицуулалт бүхий байгууллага нь иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд иргэний нийгмийн байгууллагын үндсэн шинж чанарыг өөртөө нэгэн адил агуулна.

2.3.Иргэний нийгмийн байгууллагууд хөгжлийнхөө түвшин, хараат бус байдал, нөлөөлөх чадварынхаа хувьд хоорондоо ялгарах боловч дараах нийтлэг шинж чанарыг агуулна:

2.3.1.нийтийн ашиг тусад чиглэсэн зорилготой, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, ашгийн төлөө бус буюу олсон аливаа орлогоосоо ашиг хуваарилдаггүй, нийтэд эсхүл гишүүддээ үйлчилдэг, тодорхой зохион байгуулалт, өөрийн удирдлагын бүтэц бүхий, засаг төрөөс хараат бус;

2.3.2.иргэдийн эрх ашиг, хэрэгцээг төлөөлөн илэрхийлэх, хүний эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг хүлээдэг;

2.3.3.төрийн аливаа дарамт, шахалт, нөлөөнөөс ангид байх бөгөөд энэ нь ардчиллыг гүнзгийрүүлэх, нийтлэг эрх ашиг, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, нийгмийн өөрчлөлтийг нэхэн шаардах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа шударга, үр дүнтэй явуулах гол нөхцөл болдог.

2.4.Албан эсхүл албан бус бүлэг хэлбэрээр зохион байгуулагдах иргэний нийгмийн байгууллагыг төлөвшүүлэн бэхжүүлэх нь иргэний нийгмийн хөгжлийг хангах үндсэн арга зам мөн.

ГУРАВ.ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС, САХИХ ЗАРЧМУУД

Хүний эрх, үндсэн эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хамгаалах эрхэм зорилгын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор ардчилсан

төр, иргэний нийгмийн байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хамтын үнэт зүйлс, нийтлэг зарчмыг удирдлага болгоно.

3.1.Нийтлэг үнэт зүйлс

3.1.1.Иргэний орон зай

Иргэний орон зай буюу иргэд эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан явуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрх чөлөөг баталгаатай эдлэх ба үүгээр улс төрийн, иргэний эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхээ нэхэн хэрэгжүүлэх, улс төрийн болон нийгмийн институцуудад нөлөөлөх боломжийг олгосон биет, цахим болон эрх зүйн орчныг тэтгэн хамгаална.

3.1.2.Эрүүл, аюулгүй орчин

Байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд экологийн тогтвортой байдал, хүний хөгжлийг хангахад чиглэсэн, байгаль орчны болон уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн буюу өртөх эрсдэл бүхий бүлгүүдийн оролцоог тусгасан чадавх, шинэлэг шийдлүүд шаардлагатай. Энэхүү чадавх, шийдлийг агуулсан төрийн цэгцтэй бодлого, үйл ажиллагааг иргэний нийгмийн идэвхтэй оролцоотой тодорхойлон төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.1.3.Хүний эрхэд суурилсан хөгжил

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөний бодит хэрэгжилт нь төр, иргэний нийгмийн үйл ажиллагаа, хоорондын харилцаа, хамтын ажиллагааны чанар, үр өгөөжийн гол шалгуур болно.

Монголын төр бүхий л бодлого, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хөгжлийн стратегийг баримталж тэгш бус байдал, эмзэг, өртөмтгий байдал, нийгмийн гадуурхал, алагчлал зэрэг ядуурлыг бий болгодог тогтолцооны чанартай хүчин зүйлсийг арилган, хүний улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, иргэний эрхийг хангана. Монголын иргэний нийгэм нь энэхүү хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлогыг бүх талаар дэмжинэ.

3.1.4.Хууль дээдлэх ёс

Хууль дээдлэх ёс нь хүний эрхэд суурилсан хууль тогтоомжийг хараат бус шүүх, авлигаас ангид хууль сахиулах байгууллага шударгаар хэрэгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ялангуяа нийгмийн эмзэг, гадуурхагдсан бүлэг, цөөнхийн эрхийг бүрэн, аливаа алагчлалгүйгээр хамгаалахад оршино.

3.1.5. Олон янз байдал, үл ялгаварлал

Үндэс, угсаа, нас, хүйс, хэл соёл, бие махбодын чадамж, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, эрүүл мэндийн байдал, нийгмийн гарал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон эдгээрээс үүдэлтэй эрх ашиг, хэрэгцээ, амьдралын хэв маяг зэрэг шинж чанараараа хувь хүний, бүлгүүдийн онцлог, ялгаатай чанар нь нийгмийн баялаг мөн.

Төр болон иргэний нийгмийн энэхүү олон янз байдлыг ойшоон ухаарах, үйл ажиллагаандаа нийгмийн бүлэг, хун бүрийн санаа бодол, хэрэгцээг тусган харгалзах чадвар нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үндсэн шинж чанар мөн.

Иргэний нийгмийн байгууллагууд эрх ашгаа хамгаалах чадвараар дутмаг нийгмийн эмзэг бүлэг, иргэдийг тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд дайчлах,

шийдвэр гаргахад дуу хоолойг нь тусгах, амьдралын чанарыг нь дээшлүүлэх шинэлэг арга хэлбэрийг эрэлхийлэн нэвтрүүлдэг. Уг байгууллагуудын энэхүү олон талт, эрчтэй үйл ажиллагаа иргэний нийгмийн мөн чанар, давуу талыг илэрхийлнэ.

Хөгжлийн үр шимээс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд нийгмийн эмзэг, гадуурхагдсан бүлэг, цөөнх бүлгийг эн тэргүүнд тодорхойлж, хөгжлийн явцад өөрчлөн эрэмбэлж болно. Үүнд:

- а) хүүхэд өсвөр үеийнхэн;
- б) хөдөөгийн ядуу иргэд;
- в) үндэстний цөөнх;
- г) ажилгүй, ур чадваргүй залуус;
- д) охид эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эрчүүд;
- е) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс;
- ё) ахмад настан;
- ж) хот суурин газрын ядуу иргэд, дотоодын шилжин суурьшигчид;
- з) бэлгийн цөөнх;
- и) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид.

3.1.6.Хүлээцтэй хандлага

Хүлээцтэй хандлага нь бусдын эрх, үндсэн эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх үзэлд суурилсан идэвхтэй байр суурь юм.

Хувь хүн, хамт олон, төр нь хүлээцтэй хандлагыг тус тусын үйл ажиллагаанд хэвшүүлэх нь ардчилал, нийгмийн эв эе оршин тогтнох чухал нөхцөл мөн.

Хүлээцтэй хандлага нь хувь хүн, нийгмийн бүлгийг бусдаас ялгаатай шинжээр нь дарамтлах, хүчирхийлэх үйлдэлд буулт хийх, түүнийг өөгшүүлэхийн аливаа утгыг агуулахгүй бөгөөд хүн эсхүл бүлэг хүний нэр төр, үнэ хүнд, эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдлийг хаацайлах үндэслэл болохгүй.

3.1.7.Нийгмийн эв эе, шударга ёс

Хүчирхэг иргэний нийгмийн бүтээж чаддаг нийгмийн хэлцэл, ашиг сонирхлын өргөн төлөөлөл нь ардчилал, нийгмийн эв эеийн оршин тогтнох үндэс юм.

Иргэний нийгмийн байгууллагууд иргэдийн хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлж нийгмийн амьдралыг хамтын ажиллагаа, эв санааны нэгдэлд суурилуулж өгдөг.

Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаагаар дамжин төрийн бодлогод нийгмийн оролцогчдын олон талт сонирхол тусгалаа олсноор нийгэмд өргөн хүрээний зөвшилцөл бий болж шударга ёс тогтоно.

3.1.8.Сайн дурын, хүмүүнлэгийн үйлс

Төр, иргэний нийгмийн байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдээс сайн дурын үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, нийтийн ашиг сонирхлыг хангах, хүмүүсийн амьжиргаа, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор өмч хөрөнгөөсөө буцалтгүй тусламж олгосон, цаг зав, хөдөлмөрөө үнэ төлбөргүй хандивласан ивээн тэтгэлгийн үйл ажиллагааг хүмүүнлэг ёс, нийгмийн эв санааг дэмжсэн санаачилга гэж үзэн хөхиүлэн дэмжинэ.

3.2.Үнэт зүйлсийг баталгаажуулах зарчим

3.2.1.Тэгш боломжийг хангах

Төрийн болон иргэний нийгмийн байгууллага хүний эрхийг үндэс, угсаа, нас, хүйс, бие махбодын чадамж, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, газар зүйн байршил, шилжилт хөдөлгөөн болон бусад шинжээр үгүйсгэх, ялгаварлах, хязгаарлахгүйгээр шийдвэр гаргах, хөгжлийн үйл явцад оролцох, үр шимээс нь хүртэх боломжийг бүрдүүлэхийн төлөө хамтран ажиллана.

Хүмүүсийн хэрэгцээ нийгмийн бүлгээр, газар зүйн байршлаар ялгаатай байхын зэрэгцээ байнга хувьсдаг тул эдгээр хүн, түүнчлэн эмзэг, гадуурхагдсан бүлгүүдийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий иргэний нийгмийн байгууллага, бүлгүүд шинээр үүсэх ба үйл ажиллагаа явуулах төрөл, хэлбэр арвижин нэмэгдэхийг дэмжинэ.

3.2.2.Харилцан хүндэтгэх

Төр, иргэний нийгэм нь улс орныхоо хөгжлийг хангах үйл хэрэгт гүйцэтгэх тус тусын ялгаатай бөгөөд харилцан шүтэлцээтэй үүрэг, хариуцлагаа ухамсарлан хоорондоо болон холбогдох бусад талуудтай тэгш эрхтэй, харилцан хүндэтгэлтэйгээр хамтран ажиллана.

Аливаа хүчирхийлэл, түрэмгийллээс ангид байх эрх чөлөөг дээдлэн бүгдэд хүндэтгэлтэй, тэгш хандана.

3.2.3.Иргэний нийгмийн бие даасан хараат бус байдлыг эрхэмлэн дээдлэх

Төрийн байгууллага нь иргэний нийгмийн төлөөлөлтэй тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран түүний хараат бус, эрх чөлөөт байдлыг хүндэтгэнэ.

Иргэний нийгмийн байгууллага нь төрийн байгууллагатай тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран хэлэлцэж байгаа асуудалд зарчмын байр сууринаас хандаж, хараат бус байдлаа эрхэмлэн дээдэлнэ.

Иргэн болон иргэдийн байгууллага, бүлгүүд хэрэгжүүлэх зорилго, зорилтоо өөрсдөө тодорхойлж үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн хүрээнд явуулах эрхийг төр хүндэтгэж иргэний нийгмийн байгууллага улс төрийн нөлөөллөөс ангид байх орчныг бүрдүүлнэ.

3.2.4.Бодлогын хэлцэл явуулах

Төр, иргэний нийгэм нь орон нутаг, бүс, үндэсний түвшинд зөвлөлдөх, хамтран ажиллах бүтцүүдийг хөгжлийн бодлого, үйл ажиллагааны чанар, үр дүнг баталгаажуулахад шаардлагатай нийгмийн суурийг өргөжүүлэх зорилгоор бий болгож тогтмолжуулна.

3.2.5.Бодит, тэгш оролцоог хангах

Идэвхтэй оролцоо нь хүмүүс нийгмийн нөөц, баялаг болон хөгжлөөс тэгш хүртэх илүү боломжийг бий болгодог тул иргэд, ялангуяа эмзэг, гадуурхагдсан эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн бүлгүүд, тэдгээрийг төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудыг төрийн бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан үнэлэх ажилд татан оролцуулна.

Төрийн болон иргэний нийгмийн байгууллага нь нийгмийн эгэх хариуцлагыг эрхэмлэн оролцогч талуудад тухайн асуудалтай холбоотой мэдээллийг урьдчилан хүргүүлэх, саналаа бэлдэх, танилцуулах хангалттай цаг хугацаа олгох, саналыг нь хэрхсэн тухайгаа эгэх холбоогоор мэдэгдэх үүргийг хүлээнэ.

3.2.6.Ил тод байх, хариуцлага хүлээх

Төр, иргэний нийгэм нь үйл ажиллагаа, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайн засаглалын суурь зарчмын хувьд эрхэмлэн дээдэлнэ.

Төр иргэний нийгмийн байгууллагын нууцлалын эрхийг бусад хуулийн этгээдийн эрхийн адил хүндэтгэх бөгөөд мэдээллийн ил тод, нээлттэй байдлын зарчмыг хэрэгжүүлэх нь иргэний нийгмийн байгууллагын үйлчлүүлэгч, сайн дурын болон орон тооны ажилтан, холбогдох гуравдагч талд аливаа сөрөг үр дагавар учруулахгүй.

Төрийн болон иргэний нийгмийн байгууллага гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнийхээ чанар, үр дүн ба үр дагавар, төсвийн үр ашигтай захиран зарцуулалтыг олон нийт, дэмжигч иргэд, зорилтот бүлэгт нээлттэй, ил тод тайлагнах, мэдээлэх болон хариуцлага хүлээх, тооцох тогтолцоотой байна.

Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын зохицуулалт нь тухайн иргэний нийгмийн байгууллагын чадавх чадамжтай дүйцсэн байх бөгөөд үйл ажиллагааных нь эцсийн үр дүн, чанарыг зорилтот бүлгийн хүлээлтээр тодорхойлдог онцлогийг төрийн болон хөндлөнгийн үнэлгээний арга зүйд харгалзана.

3.2.7.Авлигаас ангид байх

Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь гэрээ, төслөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэх, төрөөс бусад төрлийн санхүүжилт авах иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулахдаа сонирхогч талуудтай ашиг сонирхлын зөрчилтэй, авлига дагуулж болзошгүй аливаа харилцаанд орохгүй.

Иргэний нийгмийн байгууллага нь өөрийн мөн чанар болох хараат бус байдлаа хамгаалах үүднээс энэхүү харилцаанд өртөхөөс сэргийлнэ.

Төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд өөрийн удирдлага, үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг чанд сахина.

ДӨРӨВ. ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНЭТ ЗҮЙЛС, ЗАРЧМЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭ

Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын зорилго нь иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагын чадамжийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгоход оршино.

Энэ хүрээнд Иргэний орон зайг хуульчлан хумих, үндэслэлгүйгээр хязгаарлах, төрд тавих хяналтыг сулруулах, цаашилбал иргэний нийгмийг үр нөлөөтэй ажиллах боломжгүй болгох ямарваа хууль тогтоомж, бодлого, шийдвэр гаргахгүй байх бөгөөд чингэхийг Монгол Улсад ардчилсан улс төрийн соёл тогтох, нийгэмшсэн иргэн төлөвшихийн үндсэн нэгэн нөхцөл мөн гэж үзнэ.

4.1.Энэхүү бодлого нь нийгмийн капитал, нийгмийн шинэтгэл болон нийгмийн эдийн засгийн тухай ойлголтод тулгуурлан, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж иргэний нийгмийн байгууллагын үндсэн чиг үүргийг бодитой

хэрэгжүүлэх нөхцөлийг хангана. Эдгээр ойлголтыг энэ бодлогын хүрээнд дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

4.1.1.Нийгмийн өв хөрөнгө (нийгмийн капитал)-ийн тухай ойлголт

Нийгмийн капитал бол нэг талаас нийтлэг зорилго хэрэгжүүлэхийн тулд хүмүүсийг холбон нэгтгэдэг хэм хэмжээ, үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, нөгөө талаас, нийгмийн зохион байгуулалтын албан болон албан бус бүтэц, холбоо харилцаанаас тогтох материаллаг бус хөрөнгө нөөц юм.

Аливаа хамт олон тодорхой хэмжээний нийгмийн капиталтай байдаг бөгөөд энэ хөрөнгө нөөц их байх тусам хамт олон нийтлэг ашиг сонирхлоо хангах, хөгжлийн тулгамдсан асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх чадавх нь нэмэгддэг.

Нийгмийн капиталыг бүрдүүлэх, арвижуулах, дайчлах үүргийг гол төлөв иргэний нийгмийн байгууллага, ялангуяа анхан шатны бүл хамтлаг гүйцэтгэдэг тул нийгмийн капитал арвин байх эсэх нь иргэний нийгмийн хөгжил, чадамжаас шууд хамаарна.

4.1.2.Нийгмийн инновацын тухай ойлголт

Нийгмийн инновац гэж нийгмийн хэрэгцээг өнөөгийн шийдлээс илүүтэй хангахын зэрэгцээ чадавх болон харилцааг шинээр эсхүл сайжруулж хөгжүүлсэн, хөрөнгө нөөцийн илүү үр ашигтай зарцуулалтыг дагуулсан шинэлэг бараа, үйлчилгээ, загвар, зах зээл, ажиллагаа зэргийг ойлгоно. Иргэний нийгмийн байгууллага нь нийгмийн инновацыг хамт олны түвшинд санаачлах, түгээн дэлгэрүүлэхэд манлайлах үүргийг биелүүлдэг.

Хүнд хүрч ажиллахын мэдлэг туршлага, үйл ажиллагааны уян хатан, шуурхай, мэдрэмжтэй чанар, бүтээлч сэтгэлгээ, үр ашгийн арга ухаан, цогц хандлага зэрэг иргэний нийгмийн байгууллагын онцлог шинж чанар нь нийгмээрээ суралцаж, нийгэм-эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Иргэний нийгмийн үйл ажиллагаа өрнөхийн хирээр нийгмийн инновацыг дэлгэрүүлэх боломж нэмэгдэнэ.

4.1.3.Нийгмийн эдийн засгийн тухай ойлголт

Нийгмийн эдийн засаг гэж аливаа улс төр, нийгэм-эдийн засаг, соёл, газар зүйн байршил зэрэг шинжээр гадуурхагдсан бүлгийг хамгаалан дэмжих, нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн, гол төлөв орон нутгийн бүлийн түвшинд явуулдаг ашгийн төлөө бус аж ахуйн үйл ажиллагааг ойлгоно.

Нийгмийн эдийн засгийн байгууллага нь аж ахуйн нэгжийн нэгэн адил бараа, үйлчилгээгээ зах зээл дээр борлуулдаг боловч олсон орлогоо ногдол ашиг хуваарилахгүйгээр нийтийн болон хамт олны ашиг тусын тулд ил тод зарцуулдаг.

Нийгмийн эдийн засгийн чиг баримжаатай иргэний нийгмийн байгууллагууд нь соёлын үнэт зүйлсийг бүтээх, ажлын байр нэмэгдүүлэх, ажил мэргэжлийн ур чадвар олгох, хамт олны дунд өөртөө туслах сүлжээ бий болгох, орчноо тохижуулах, байгаль хамгаалах, эмзэг болон гадуурхагдсан бүлгүүдийг чадавхжуулах болон хамт олны хөгжлийн бусад хэрэгцээг хангах чиглэлээр ажилладаг орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих уян хатан бөгөөд тогтвортой бүтцүүд юм.

4.2.Төрийн бодлогын стратегийн чиглэлүүд

Иргэний нийгмийн хөгжлийг дэмжихэд баримтлах төрийн бодлогын хүрээнд дараах стратегийн чиглэлүүдийг тодорхойлж байна:

- Ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.

4.2.1.Ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх

Ардчилсан улс төрийн соёл гэж ардчилсан нийгэм, сайн засаглалын талаар иргэдийн нийтээр баримталдаг үнэт зүйлс, итгэл үнэмшил болон үүнээс улбаатай хандлага, дадлыг хэлнэ. Улс төрийн соёл нь иргэд аливаа асуудлаар санал нийлэх бус, харин нийгмийн гишүүн бүрийн эрх, үүрэг болон улс төрийн үйл явцад оролцох хэм хэмжээний тухай нэг мөр ойлголттой байх явдал юм.

Энэхүү ойлголтын үүднээс дараах арга хэмжээг авна:

4.2.1.а.Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөний бодит хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор хууль тогтоомжийг хүний эрхийн талаас хянан үнэлж, иргэний нийгмийн байгууллагаас хүний эрхийг хамгаалах болон төрийн байгууллага, түүний удирдах ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих, нөлөөлөх үндсэн чиг үүргээ аливаа саад, дарамтгүй гүйцэтгэх бололцоог хангана.

4.2.1.б.Төрийн алба, түүний дотор хууль сахиулах, шүүх засаглалын байгууллагын албан хаагчдын иргэний нийгмийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулан төлөвшүүлж, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах туршлага, чадавхийг бүрдүүлнэ.

4.2.1.в.Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны нийгмийн үнэлэмжийг дээшлүүлж иргэний нийгмийн байгууллагын ажилтан, идэвхтэн, сайн дурын ажилтныг мэргэшсэн ажиллах хүчний чухал нөөц гэж үзнэ.

Иргэний нийгмийн байгууллага, ашгийн төлөө бус салбарт ажилласан туршлагыг төрийн албаны хүний нөөцийн шалгуур үзүүлэлт болгож, төрийн албанд сонгон шалгаруулахад давуу талд тооцно.

4.2.1.г.Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт, эдгээрийн хэрэгжилтийн үйл явц, үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, тогтмол шинэчилсэн байдлаар хүргэх чадавхыг нэмэгдүүлж, дагаж мөрдөх журмыг тогтооно.

4.2.1.д.Ардчилсан үзэлтэй, ёс суртахуунтай, бүтээлч сэтгэлгээтэй, өрсөлдөх чадвартай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор бүх шатны албан болон албан бус боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрх, иргэний боловсролын агуулгыг тусган шинэчилж, үүнд чиглэсэн иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

4.2.2.Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Иргэдийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд татан оролцуулах нь ардчилсан төрөөс ухамсартайгаар хийж байгаа эрх мэдлийн дахин хуваарилалт мөн бөгөөд энэ нь иргэд аж байдалд нь шууд хамаарах асуудлыг шийдвэрлэхэд өөрсдөө оролцох эрхээ бодитой эдлэх чухал нөхцөл юм.

Иргэний нийгмийн байгууллага нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад иргэдийн оролцоог хангах гол механизм болно.

4.2.2.а.Хуулийн болон бодлогын баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх үйл ажиллагааг цахим хуудсанд байршуулснаар хязгаарладаггүй, иргэдийн саналыг хууль тогтоомжид тусгасан эсэх талаар эгэх холбоогоор мэдээлдэг, түүнчлэн эдгээр төслийг тухайн чиглэлээр ажиллаж мэргэшсэн төрийн бус байгууллага боловсруулдаг зэрэг дэлхийн тэргүүн туршлагыг харгалзан холбогдох дүрэм журмуудыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг нь тогтмол үнэлэн сайжруулж байна.

4.2.2.б.Орон нутаг, бүс, үндэсний түвшинд хөгжлийн асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх үйл ажиллагаанд иргэний нийгмийг оролцуулах арга механизмыг боловсронгуй болгож, улмаар ийм үйл ажиллагааг иргэний нийгмийн байгууллага санаачлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.

4.2.2.в.Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн үйл ажиллагаа болон төсвийн захиран зарцуулалтын үйл явц, үр дүнг ялангуяа орон нутгийн түвшинд иргэний нийгэм, түүний байгууллагуудын оролцоотой тогтмол хэлэлцдэг журам тогтоож хэрэгжүүлнэ. Уг олон нийтийн оролцооны журмыг Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нутгийн өөрөө удирдах болон орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг цэгнэх үр дүнгийн үнэлгээнд хэрэгжилтийг илтгэсэн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтүүдийн хамт тусгана.

4.2.3.Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх

Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа нь хоёр талын хүсэл зориг, ажил хэрэгч хандлага, бие биеэ нөхөн гүйцээсэн чадамжийг оновчтой ашиглахыг шаардана.

4.2.3.а.Иргэний нийгмийн байгууллагын талаарх бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Иргэний нийгмийн байгууллагын талаарх хууль тогтоомж нь иргэний ухамсар, санаачилгын ундарга болсон иргэний нийгмийн орон зайг хамгаалан хөгжүүлэх, төрд тавих хяналтыг сайн засаглалын хэрэгслийн хувьд төлөвшүүлэх, иргэний нийгмийн нийтэд тустай үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй,чөлөөтэйявуулах орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

1.Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг Монголын иргэний нийгмийн хөгжлийн чиг хандлага болон олон улсын хэм хэмжээ, аргазүй, туршлагад нийцүүлэн шинэчилнэ:

а)Нийгэмд ашиг тустай үйл ажиллагааны чиглэл, иргэний нийгмийн байгууллагын төрөл хэлбэрийн тодорхойлолт, ангиллыг иргэний нийгмийн хөгжлийг олон улсын харьцуулалтын үндсэн дээр дүгнэн үнэлэх зорилгоор олон улсын арга зүйд нийцүүлэн хуульчилна.

б)Иргэний нийгмийн байгууллага сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх эрх ба үйл ажиллагаагаа бүртгэлгүй явуулах эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, сайн

туршлагын дагуу хүлээн зөвшөөрнө. Иргэний нийгмийн байгууллагын бүртгэл, тайлагналтын журмыг уян хатан болгож, иргэний нийгмийн байгууллагын хүч, хэмжээ зэрэг онцлогийг харгалзан үйл ажиллагаанд нь хэт ачаалал, зардал учруулахгүйгээр боловсруулж тогтооно. Бүртгэхээс татгалзах үндэслэлийг нарийн тогтоож, татгалзсан шалтгааныг бичгээр тайлбарлах журам нэвтрүүлнэ.

в)Иргэний нийгмийн байгууллагыг зөвхөн түүний удирдах дээд байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу татан буулгахаас бусад тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр татан буулгах журмыг хуулиар тогтооно.

г)Төрөөс тогтоосон иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хуульд заасан чанарын стандарт бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэх иргэний нийгмийн байгууллагын хувьд хэрэглэнэ. Уг журамд тэгш эрхийн зарчмыг харгалзан хувийн хэвшлийн болон бусад байгууллагад тавьдгаас илүү шаардлага тавихгүй.

Иргэний нийгмийн байгууллагуудаас зөвшилцөн боловсруулсан ёс зүйн хэм хэмжээний үндсэн дээр олгох магадлан итгэмжлэлийг төр хүлээн зөвшөөрч иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэхийг хуулиар шаардсан арга хэмжээнд хэрэглэж болно.

2.Иргэний нийгмийн байгууллагад стратегийн өмгөөлөл эрхлэх эрхийг олгосон хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж уг эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулж буй шалтгааныг тогтоож арилгана. Энэхүү хууль тогтоомжид заасан нийтийн эрх ашигт хамаарах асуудлын хүрээг өргөжүүлэн хуульчилна.

3.Иргэний нийгмийн байгууллагаас төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг хуулиар баталгаажуулж, түүнээс гүйцэтгэсэн хяналтын үр дүнгийн талаар холбогдох төрийн байгууллага дүгнэлт гаргаж, хяналтын мөрөөр авах арга хэмжээгээ иргэний нийгмийн байгууллагад бичгээр мэдэгдэх үүрэг хариуцлагыг хуульчлан тогтоох замаар иргэний нийгмийн байгууллагаас гүйцэтгэсэн хяналтыг эрх зүйн үр дагавартай болгоно.

4.2.3.б.Иргэний нийгмийн байгууллагын тогтвортой хөгжлийг төрөөс дэмжих

Тууштай зорилго, зохистой удирдлага, санхүүгийн олон тулгуурт эх үүсвэртэй байх нь иргэний нийгмийн байгууллагын тогтвортой байдлыг тодорхойлно.

Иргэд болон иргэний нийгмийн байгууллагаас нийтийн эрх ашгийн төлөө явуулж байгаа үйл ажиллагааны чанар, цар хүрээг нэмэгдүүлэх, ивээн тэтгэлэг болон сайн дурын үйлсийг хөхиүлэн дэмжих, иргэний нийгмийн байгууллагын дотоодын болон олон улсын санхүүжилтийн эх үүсвэрийг хамгаалах зэрэг аргаар чадавхыг нь дээшлүүлэхийн тулд төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх тууштай бодлого баримтална.

1.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь шууд болон шууд бус хэлбэртэй байна. Шууд дэмжлэг нь төрөөс иргэний нийгмийн байгууллагад олгож байгаа гэрээ, төсөл болон бусад хэлбэрийн мөнгөн буюу мөнгөн бус тэтгэлэг байх болно. Шууд бус дэмжлэг нь иргэний нийгмийн байгууллага болон иргэд, хувийн хэвшлийн этгээдээс нийтэд ашиг тустай үйл ажиллагаа явуулах, ивээн тэтгэхийг хөхиүлэн дэмжсэн татварын зохицуулалт байна. Үүнд иргэний нийгмийн байгууллагыг орлогын албан

татвар, бусад татвар хураамжаас чөлөөлөх, ивээн тэтгэгч иргэд, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ багтана.

Олон улсын болон гадаадын санхүүжилт иргэний нийгмийн байгууллагын үндсэн зорилго, бие даасан байдал, тогтвортой үйл ажиллагааны чухал баталгаа мөн тул хуулиар тогтоох санхүүгийн болон бусад төрлийн хяналт уг санхүүжилтийн зорилго, хэмжээтэй дүйцсэн байна.

2.Иргэний нийгмийн байгууллагын нийтэд ашигтай үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэн болон хувийн хэвшлийн нийгмийн хариуцлага, ухамсрыг төлөвшүүлэх, улмаар хүмүүсийн харилцан туслалцаа, хамтын ажиллагаанд суурилсан нийгмийн эв зөийг бататгах зорилгоор иргэний нийгмийн байгууллага болон ивээн тэтгэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих татварын чөлөөлөлт, хөнгөлөлт зэрэг арга хэмжээг төрийн бодлого, хуулиар хамгаална.

3.Иргэний нийгмийн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийг хангах үүднээс төрийн шууд болон шууд бус дэмжлэгийн төрөл хэлбэрийг өөрийн орны санхүү-эдийн засгийн чадавх болон олон улсын жишигт нийцүүлэн тууштай нэмэгдүүлнэ.

4.Иргэний нийгмийн ашгийн төлөө бус этгээдийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Ингэхдээ бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэхээс гадна бүх нийтийн сайн сайхан, үндэсний эв санаа, ардчиллыг дэмжин дэлгэрүүлэхэд нийгмийн үнэ цэн бүхий хувь нэмрийг оруулах онцгой чадавхтай ашгийн төлөө бус байгууллагуудыг зах зээлд оролцож үр шимээс нь хүртэх явцад энэхүү нийгмийн баялгийг бүтээх чиг үүргээсээ гажих эсхүл няцахад хүргэхээс сэргийлсэн хамгааллын арга хэмжээг бий болгоно.

5.Төрөөс иргэний нийгмийн байгууллагуудад гэрээ, тэтгэлгийн хэлбэрээр олгох санхүүжилтийг тэдгээрээс нийлүүлэх ажил, үйлчилгээний чанар, үр өгөөжийг, нөгөө талаас төрийн санхүүжилтийн үр ашгийг баталгаажуулахын тулд хангалттай хэмжээ, хугацаатайгаар олгохоор төлөвлөж гүйцэтгэнэ.

6.Төрөөс болон бусад эх үүсвэрээс иргэний нийгмийн байгууллагад олгосон санхүүжилтийн зохих хэсгийг тухайн байгууллагын хөгжлийн хэрэгцээг хангах зорилгоор захиргааны зардал болгон ашиглах зохицуулалтыг боловсронгуй болгоно.

7.Төрийн санхүүжилтийг иргэний нийгмийн байгууллагуудад хуваарилах үйл ажиллагааг нийтлэг журмын дагуу, ил тод, орон нутагт хүртээмжтэй байдлаар зохион байгуулж явуулна.

8.Иргэний нийгмийн талаарх мэдлэгийн суурийг бэхжүүлэн хөгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжинэ.

9.Иргэний нийгмийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг төлөвшүүлэх зорилгоор иргэний нийгмийн байгууллагуудын цахим мэдээллийн сүлжээ байгуулах, тогтвортой үйл ажиллагааг нь хангахад тусална.

10.Иргэний нийгмийн байгууллагууд нь иргэний нийгэмд итгэх олон нийтийн итгэлийг бататгах, төртэй болон өөр хоорондоо явуулах хамтын ажиллагаа, дотоод үйл ажиллагаандаа ардчилал, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих зорилготой өөрийн зохицуулалтын арга механизмыг боловсронгуй болгохыг хөхиүлэн дэмжинэ.

11.Хууль тогтоомж болон иргэний нийгмийн байгууллагын хуульд заасан эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих төрийн чадавхыг боловсронгуй болгоно.

ТАВ.ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

5.1.Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг чанд баримтална:

5.1.1.Төрийн болон иргэний нийгмийн байгууллага үлгэр дууриалал үзүүлж, санаачилгатай, хариуцлагатай, тууштай үйл ажиллагаагаараа манлайлан ажиллах;

5.1.2.Холбогдох нийт талуудын оролцоо, хамтын ажиллагааг бүх түвшинд хангах;

5.1.3.Үйл ажиллагааг харилцан зөвшилцсөн, бодит мэдээлэл, судалгаанд тулгуурласан, өртөг зардлыг нь тооцсон төлөвлөлтийн үндсэн дээр хэрэгжүүлэх;

5.1.4.Иргэний нийгмийн байгууллагын оролцоог мэргэшил, төлөөллийн зарчмаар тодорхойлох;

5.1.5.Хэрэгжилтэд хамтын хяналтын тогтолцоог бий болгож, үйл явц, үр дүнг олон нийтэд ил тод, тогтмол мэдээлэх;

5.1.6.Энэхүү бодлого болон түүнтэй нийцүүлэн гаргасан төрийн бодлого, шийдвэрийг эс биелүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох.

5.2.Хэрэгжүүлэх механизм

5.2.1.Иргэний нийгмийн асуудал эрхэлсэн чиг үүргийг хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын хүрээнд бий болгож төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн олон талын оролцоо бүхий талбарыг төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргаа болон өөрөө удирдах байгууллагад бүрдүүлнэ.

5.2.2.Энэхүү бодлогод тулгуурласан төрийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэний нийгмийг төлөөлж төрийн байгууллагатай үндэсний болон орон нутгийн түвшинд хамтран ажиллах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий өөрийн удирдлагын бүтцийг иргэний нийгмийн байгууллагууд дундаасаа нээлттэй, ил тод, өргөн оролцооны зарчмаар үүсгэн байгуулна.

5.2.3.Иргэний нийгмийн хөгжил, төр болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааг хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт, дунд болон богино хугацааны баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

5.2.4.Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.

ЗУРГАА.БУСАД

6.1.Бодлогын үнэт зүйлс, зарчмыг эрхэмлэн дээдлэх

Төр, иргэний нийгэм нь энэхүү бодлогод тунхагласан ардчилсан нийгэм, сайн засаглалын үнэт зүйлс, зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон чанд сахиж, гуйвалтгүй мөрдөнө.

6.2.Бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

Бодлогод иргэний нийгмийн хөгжил дэвшлийг цаашид гүнзгийрүүлэхэд чиглэсэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт хийж болно. Ингэхдээ төр, иргэний нийгэм хоорондоо зөвшилцөх, хоёр талын тэгш оролцоог хангах, ил тод байх зарчмыг баримтална.

—oOo—

**ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ТАЛААРХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ
(2023-2033)**

Зорилго 1.Төрөөс иргэний нийгмийн хөгжил, хамтын ажиллагаа, оролцоог хангах замаар бүлгийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах, хэрэгжүүлэх цогц бодлого, оновчтой механизмтай байна.

Зорилт 1.1.Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаагаар дамжин төрийн бодлогод нийгмийн оролцогчдын олон талт сонирхлыг тусгах, төрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог тодорхой болгох, нийгэмд өргөн хүрээний зөвшилцөл бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

Үйл ажиллагаа 1.1.1.Иргэний нийгмийн байгууллагын олон улсын чиг хандлагад тулгуурласан эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангана.

Үйл ажиллагаа 1.1.2.Хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах тогтолцоонд засаглал болон төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны үзүүлэлтийг тусгана.

Зорилт 2.1.Иргэний нийгмийн байгууллагын институцийн төлөвшлийг дэмжиж, улс төрийн нөлөөллөөс ангид тогтвортой, үр дүнтэй, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үйл ажиллагаа 2.1.1.Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.

Үйл ажиллагаа 2.1.2.Иргэний нийгмийн байгууллагын тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн олон тулгуурт эх үүсвэрийг баталгаажуулсан тогтолцоог нэвтрүүлнэ.

Үйл ажиллагаа 2.1.3.Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд төрийн бус байгууллага болон сонирхогч аливаа этгээд захиргааны болон иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлнэ.

Үйл ажиллагаа 2.1.4.Төрийн байгууллага нь иргэний нийгмийн төлөөлөлтэй тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран хараат бус, эрх чөлөөт байдлыг ханган ажиллахыг хууль тогтоомжоор баталгаажуулна.

Үйл ажиллагаа 2.1.5.Иргэний нийгмийн байгууллагыг бүртгэлгүй гэсэн үндэслэлээр төрийн үйл хэрэгт оролцох, үйл ажиллагаа явуулах, оролцох эрхийг хязгаарлахгүй байх баталгааг хангана.

Зорилт 3.1.Авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.

Үйл ажиллагаа 3.1.1.Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, ёс зүй, шударга ёсны тогтолцоог эрхэмлэсэн соёлыг хэвшүүлнэ.

Үйл ажиллагаа 3.1.2.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах механизмыг тодорхой болгох, иргэд, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын байгууллагын чадавхыг сайжруулж, төлөвшүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль, шүүхийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

—oOo—